



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2005 оны 4 сарын 14 одор

Дугаар 143

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын түчай" хуулийн 28 дугаар зүйлийн 3 дахь заалт, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын дүрмийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар /Д.Энхбаяр/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2001 оны 8 дугаар захирамжийн 1 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Zaki-05

0200482

Нийслэлийн Засаг даргын 2005 оны  
... сарын 17-ны өдрийн...  
143 дугаар захирамжийн хавсралт

## НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар /цаашид "Газар" тэнэ./ нь Нийслэлд боловсрол, шинжлэх ухааны бодлогыг хэрэгжүүлэх, байгууллага иргэдэд боловсрол шинжлэх ухааны үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн захирагааны байгууллага мөн.

1.2. Газар нь Төрөөс боловсрол, шинжлэх ухааны талаар баримтлагч бодлого, Боловсрол шинжлэх ухаан технологийн багц хууль, бусад хууль, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын шийдвэр. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мэрийн хөтөлбөр, захирамж энэхүү дүрмийг үйл ажиллагаандaa удирдлага болгон мөрдөнө.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга түүний орлогч, Тамгын газарт ажлаа тайлagnаж ажиллана.

1.4. Газар нь тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэж банканд харилцах данстай байна.

1.5. Газар нь Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо Нийслэлийн төр, захирагааны 4 дүгээр байранд үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

### Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалт

2.1. Газрын бүтэц орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.2. Газрын даргыг Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагатай зөвшилцэн Нийслэлийн Засаг дарга томилж чөлөөлнө.

2.3. Газрын орлогч даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцэж, газрын дарга томилж чөлөөлнө.

2.4. Газрын дарга нь батлагдсан бүтэц орон тооны дагуу мэргэжилтнүүд болон арга зүйчдийг томилж чөлөөлнө.

2.5. Газрын дарга нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн дотоод журам, хэлтэс, албаны дүрэм, ажилтнуудын цалин урамшууллыг тогтоож, эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал, журам, заавар гаргана.

2.6. Газар нь төрийн захиргааны болон мэргэжил арга зүйн нэгжтэй байна.

2.7. Газрын дүрмийг Нийслэлийн Засаг дарын захирамжаар батална.

2.8. Газрын дарга нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлж, төсвийг зарцуулна.

2.9. Газрын дэргэд байгууллагын хэтийн зорилго, зорилт чиг үүргийг төлөвлөн хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх мэргэжлийн болон захиргааны зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

2.10. Газар нь дэргэдээ боловсролын үйл ажиллагааны чанарт дээшлүүлэхэд иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн өндөр зэрэгтэй багш, эрдэмтэд, удирдах ажилтны төлөөлөл бүхий орон тооны бус "Арга зүйн зөвлөл" ажиллуулна.

2.11. Газар нь эрдэм шинжилгээ, арга зүйн бүтээл, ном, сурх бичиг, мэдээлэл сурталчилгаа, лавлагааны материал, толь бичиг бүхий номын сан, сургалтын кабинет, лаборатори, мэдээлэл, сургалтын төв, түшиц цэцэрлэг, сургуультай байна.

2.12. Газрын дэргэд Боловсрол хөгжүүлэх сан байгуулан ажиллуулж болно. Сангийн дүрмийг газрын дарга батална.

#### **Гурав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл**

Газар нь дараах үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлнэ.

3.1. Боловсрол, шинжлэх ухааны талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэлгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлagnах.

3.2. Боловсролыг хөгжүүлэх нийслэлийн хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, стратегийн төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хийх, хяналт шинжилгээ, үнэпгээ өгөх.

3.3. Зохих түвшний боловсрол эзэмшиүүлэх сургалтын байгууллагад тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Нийслэлийн Засаг дарын шилжүүлсэн эрхийн хэм хэмжээний хүрээнд зохих журмын дагуу шийдвэрлэх.

3.4. Нийслэл, дүүргийн төрийн өмчийн боловсролын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн зарлага, санхүүжилтийн гүйцэтгэлийг болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланд үнэлгээ өгөх, тогтоосон хугацаанд холбогдох байгууллаа ад тайлagnах.

3.5. Боловсролын стандарт, кирриколим /сургалтын хөтөлбөр/-ийг хэрэглэх хорёгжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллага, хүмүүст мэргэжил

арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа шинжилгээ хийх, гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг батлах, хяналт тавих

3.6. Нийслэлийн хэмжээнд сургуулиудын хамран сургах тойргийн судалгааг нарийчлан гаргаж, хорооны нийгмийн ажилтан, зохион байгууллагч нарыг мэргэжил арга зүйн сургалтанд хамруулж, удирдлагаар хангах, дүүргийн Гэгээрэл хөгжлийн төвүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх.

3.7. Нийслэлийн сургууль, цэцэрлэгийг мэргэжилтэй боловсон хүчинээр хангах бодлого боловсруулан хэрэгжүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, ажиллах нэхцэлийг хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах,

3.8. Нийслэлийн сургууль, цэцэрлэгийн багш, сургалтын менежер, арга зүйч, удирдах ажилтнуудыг төр, захиргааны байгууллагын шагналаар шагнуулах асуудлаар санал боловсруулан шийдвэрлүүлэх.

3.9. Боловсрол, сургалт, судалгаа, шинжилгээ хийх, эрдэмтэд, судлаач, ажилтнуудтай хамтран судалгаа шинжилгээ хийх, эрдэм шинжилгээний бүтээл хэлэлцэх бага хурал, сургалт, семинар, олимпиад, урацаан тэмцээн, урлагийн наадам зохион байгуулах, сурталчлах.

3.10. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, аттестатчилан, сургалтын байгууллага байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг зогсоох талаар санал, дүгнэлт гаргах,

3.11. Сургууль завсардалтыг бууруулах, иргэдэд албан ба албан бус арга замаар боловсрол, мэргэжил олгох, боловсролын чанартай үр ашигтай үйлчилгээ үзүүлэх.

3.12. Төрийн ба төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль төгсех, анги дэвших шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран дүрэм, журмын дагуу зохион байгуулах, зохих түвшний боловсрол эзэмшсэн иргэдэд олгох боловсролын гэрчилгээ, үнэмлэхийг захиалах, нэгж байгууллагад хүргэх, мэдээ тайланг цаг тухайд нь гаргах.

3.13. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг засварлах, өргөтгэх, шинээр барих шаардлага хэрэгцээг судлан шийдвэрлүүлэх, гүйцэтгэх ажлыг зохион байгуулах.

3.14. Боловсролын байгууллагыг ном, сурах бичиг, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмж, тавилга, компьютер, кабинет, лабораториор хангах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, ашиглалт, хамгаалалтыг сайжруулахад хяналт тавих.

3.15. Сургуулийн нийгмийн ажлыг хөгжүүлж, арга зүйн удирдлагаар ханган, сурагчдын өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хичээлээс гадуурх сургалтын ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

3.16. Нийслэлийн боловсрол, сургалтын байгууллагууд, багш нарын судалгаа шинжилгээний ажлыг өнөөгийн хэрэгцээ эрэлтэд нийцүүлж хөгжүүлэх, мэдээллийн технологийг сургалтанд ашиглах, төсөлт хэрэгжүүлэх чиглэлээр ижил төрлийн чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах.

3.17. Сургууль, цэцэрлэг, сургалтын байгууллагын менежмент, зохион байгуулалтыг оновчтой болгож, орчин үеийн шинжлэх ухааны ололт, технологийн дэвшилийн талаарх мэдээллээр хангах, туршилт, судалгаа шинжилгээний ажлын техникийн баазыг бэхжүүлэх, судалгааны үр дүнг нийтэд хүртээх, хэвлэн нийтлэх, эрдэм судлалын ажлыг санхүүжүүлэх шинэ эх үүсвэрийг олж дайчлах.

3.18. Шинжлэх ухааны ололт, үр дүн, дэвшилтээ технологи нэвтрүүлэхэд салбар эрдэм шинжилгээний хүрээлэн болон Их, дээд сургуулийн дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэн ыцаашид эрдэм шинжилгээний хүрээлэн гэх/гүүнчлэн холбогдох байгууллагуудын судалгаа, туршилтын талаарх мэдээлэл харицсан солилцох, ашиглуулах зорилгоор сургалт, семинар зохион байгуулах.

3.19. Хот төлөвлөлт, хүн амын бодлого, дэд бүтэц, усан хангамж, агаарын бохирдолт зэрэг тулгамдсан асуудлаар судалгаа шинжилгээ хийх, шинжлэх ухаан технологийн мэдээллийг хөгжүүлэх талаар дотоод болон гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, хотөлбөр тесел, дүрэм журам шийдвэрийн төсөл боловсруулах.

3.20. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтэст хүргүүлж хянуулах.

#### **Дөрөв. Газрын эрх, үүрэг**

4.1. Газар нь дор дурдсан эрхтэй байна.

4.1.1. Боловсрол, шинжлэх ухааны хөгжлийн асуудлаар холбогдох байгууллага, хүмүүст санал тавьж шийдвэрлүүлэх.

4.1.2. Газрын дарга нь ерөнхий боловсролын сургууль болон бусад сургалтын байгууллагын захиралтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, Нийслэлийн Засаг даргад тайлагнах.

4.1.3. Холбогдох хууль тогтоомж, газрын дотоод журмын дагуу ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг үр чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх талаар шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх.

4.1.4. Гадаад орнуудын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран харилцан ашигтай ажиллах, хандив тусlamжийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах.

4.1.5. Нийслэлийн Засаг даргаас хууль тогтоомжийн хүрээнд шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх.

4.2. Газар нь дараах үүрэгтэй.

4.2.1. Нутаг дэвсгэрийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх.

4.2.2. Багшийг аттестатчилах, багшид мэргэжлийн зэрэг болон багшпах эрх олгох, хасах талаар санал, дүгнэлт гаргах.

4.2.3. Газрын дарга нь өрөнхий боловсролын сургуулийн захирап, цэцэрлэгийн эрхлэгчийг томилж, чөлөөлөх асуудлаар Нийслэл, дүүргийн Засаг даргад санал оруулах.

4.2.4. Боловсрол, шинжлэх ухааны ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, байгууллага, ажилтнуудын хөдөлмөрийг үнэлэх, шагнаж урамшуулах, бусад дэмжлэг үзүүлэх.

4.2.5. Орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны хөгжлийн бодлогод нийцүүлэн санхүүгийн нөөцөө оновчтой хуваарилан байршуулж, тосвөө бодитой төлөвлөх, санхүүгийн гүйцэтгэлийн тайланг шаардлагын дагуу үнэн зөв гарга, холбогдох байгууллагуудад мэдээлж тайлагнах.

4.2.6. Боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төс байгууллагад статистик мэдээг зохих стандартын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргаж огох.

4.2.7. Газрын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

4.2.8. Шинжлэх ухааны технологийн дэвшлийг сурталчлах, ойлгуулах талаар боловсрол, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах.

4.2.9. Шинжлэх ухаан технологийн мэдээллийн үйлчилгээг хөгжүүлэх, гадаадын ижил чиг үүрэгтэй байгууллагатай хамтран ажиллах.

#### **Тав. Хүлээлгэх хариуцлага**

5.1. Газрын дарга, орлогч дарга, албан хаагчид нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### **Зургаа. Бусад зүйл**

6.1. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж бүртгүүлнэ.

-----oOo-----